

# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.12 №28 (28)

ҮЙЛ ЯВДАЛ

## БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГУУДАД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГЛӨВ



“Ковид-19” цар тахал эрчимтэй тархаж байгаатай холбогдуулан Засгийн газраас энэ сарын 10-25-ны хооронд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэртэй холбогдуулан БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан

шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, БХЯ-ны ТЗУГ-ын дарга, хурандаа Ч.Гандирваа, БХЗГ-ын дарга, хурандаа Х.Батсайхан нар БХЯ-ны харьяа байгууллагуудын удирдлагуудтай өнгөрсөн Баасан гарагт хуралдлаа. Хурлаар Засгийн газрын шийдвэрийн дагуу тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд

10 хүртэлх хувийн ирцтэйгээр ажиллах болсонтой холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг чандлан сахиж, дотоод журмыг мөрдлөг болгон хариуцлагыг өндөржүүлэх, иргэдээс ирсэн гомдол саналыг бүртгэж, эргэх холбоотой ажиллахыг анхааруулсны сацуу харьяа байгууллагын удирдлагуудад нэг бүрчлэн үүрэг, чиглэл өглөө.

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
Өдөр: -2	Шөнө: -10
ӨМНӨД СУДАН	
Өдөр: +33	Шөнө: +23
АФГАНИСТАН	
Өдөр: +21	Шөнө: +11

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.338.00	3.449.00
CNY	432.00	436.90
RUB	35.90	38.50
JPY	25.52	26.40
KRW	2.41	2.64


## НОГООН БАЙГУУЛАМЖ БИЙ БОЛГОХОД АНХААРНА



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр болон тус албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн ногоон байгууламж, ландшафт зураг төсөл хариуцсан мэргэжилтнүүдийг өнгөрөгч Баасан гарагт хүлээн авч уулзаж, ногоон байгууламжийн ажлын төлөвлөлтийн талаарх төслийг хэлэлцсэн юм. Тус төслийн хүрээнд нийт 11715 м<sup>2</sup> талбайд хамгаалалтын

ногоон зурвас байгуулж, эхний ээлжид 60 ширхэг 4-6 м өндөртэй том оврын нарс мод тарихаар төлөвлөжээ. Үүний эхлэл болж өнгөрөгч Бямба гарагт БХЯ-ны хашаан дахь талбайн мод бутыг хэлбэржүүлэн хортон шавжаас хамгаалж, мод шохойдох ажлыг хийж гүйцэтгэлээ. Учир нь тус талбайд олон жил арчилгаа, тордолт хийгдээгүй аж.

Батлан хамгаалах салбарын ирэх дөрвөн жилд хийж хэрэгжүүлэх ажлын нэг хэсэг нь дээрх зорилт руу чиглэх бөгөөд энэ хүрээнд



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудыг цэцэрлэгжүүлж, мод тарьж ногоон бүсийг бий болгоно. Эхний ээлжид Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг “Жишиг ногоон байгууламж”-тай болгох зорилтыг дэвшүүлээд байна. Үүнтэй уялдуулан Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг тус ангид өнгөрсөн Баасан гарагт ажилласан юм.

СПОРТ

## Б.ГАНХАЙЧ ШАГНАЛТ БАЙРТ ШАЛГАРЛАА

“Алдар” спорт хороо

Монголын жүдо бөхийн үндэсний шигшээ багийн 26 тамирчин Узбекистаны нийслэл Ташкент, Гүржийн Тбилисын “Их дуулга” олимпийн эрхийн тэмцээнд амжилттай оролцлоо.

Тус тэмцээнд БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны баг тамирчдаас нэг дасгалжуулагч, 4 тамирчин оролцсон юм. Ташкентийн “Их дуулга”-д эмэгтэйчүүдийн 63 кг-ын

эрэгтэй төрөлд 90 кг-ын жинд ОУХМ, дэслэгч Г.Алтанбагана, +100 кг-ын жинд ОУХМ, дэслэгч Ө.Дүүрэнбаяр болзлыг хангажээ. Дэлхийн жүдо бөхийн холбоо ирэх сарын 24-29-нд Унгар Улсад зохиогдох ДАШТ-ний дараа олимпод оролцох тамирчдын нэрсийг зарлах төлөвтэй байгаа аж.

Мөн Монголын чөлөөт бөхийн үндэсний шигшээ багийн баг тамирчид Казахстаны нийслэл Алмата хотод өнгөрсөн Баасан гарагт эхэлсэн чөлөөт бөхийн олимпийн эрхийн



жинд “Алдар” спорт хорооны тамирчин, дэд ахлагч Б.Ганхайч шагналт V байрт шалгарсан бол Гүржийн Тбилисын “Их дуулга”-аас эрэгтэйчүүдийн 90 кг-ын жинд ОУХМ, дэслэгч Г.Алтанбагана хүрэл медаль хүртсэн юм. Ингэснээр “Алдар” спорт хорооны жүдо бөхийн баг тамирчид олимпийн нийт 4 эрхийн болзол хангаад байна.

Үүнд эмэгтэй төрөлд 48 кг-ын жинд ОУХМ Г.Наранцэцэг, 63 кг-ын жинд ОУХМ дэд ахлагч Б.Ганхайч,

төлөөх тэмцээнд оролцож байна. Тэмцээнд “Алдар” спорт хорооноос сонгомол бөхийн төрөлд ОУХМ, М.Даваабанди, эмэгтэй 62 кг-ын жинд МУГТ С.Цэрэнчимэд нар оролцож байгаа юм. Тус тэмцээний дараа ААШТ энэ сарын 14-17-нд эхлэх бөгөөд тэмцээнд 53 кг-ын жинд ОУХМ Д.Отгонжаргал, 72 кг-ын жинд ОУХМ, ахлах ахлагч Э.Цэвэгмэд нар оролцох юм.

Хошууч Н.ОТГОНБААТАР

## ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 30  
2021.04.12.  
/ДАВАА ГАРАГ/

**ХАВРЫН ДУНД ЦАГААЧИН ТУУЛАЙ САРЫН ТАВАН ШАР ЦАГААН БАР ӨДӨР**

Үс засуулбал:

Эрлэг лугаа учирна

Наран ургах, шингэх:

06.09-19.37

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал:

Мод.

Аргын тооллын 4 дүгээр сарын 12, Сумъяа гараг. Билгийн тооллын давхарласан 30, Шийдэм одтой, цагаан бар өдөр. Өдрийн наран 6 цаг 09 минутад мандан, 19 цаг 37 минутад жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, амилуулах, өглөгийн түлээг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг цагдаагийн үйл, гээр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 14183+831	ЭДГЭРСЭН 8875+284	НАС БАРСАН 22/3
-------------------------------	----------------------	--------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНӨЛӨГ

НИЙТ БАТЛАГДСАН 1617+6	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 257+53	ЭДГЭРСЭН 1354
---------------------------	-------------------------------	------------------

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

**Тохиолдол**  
Нийт: 134,308,070

**Эдгэрсэн**  
Нийт: 109,357,713

**Нас барсан**  
Нийт: 2,907,944

### КОВИД-19 ЦАР ТАХАЛ

ДАРХЛААЖУУЛАЛТ /ДЭЛХИЙ ДАХИНД/

669,248,795

ИЗРАЙЛЬ- 61%

ИХ БРИТАНИ- 47%

ЧИЛИ- 38%

АНУ- 34%

БАХРАЙН- 33%

ДЭГЭРСЭН НИЙТ ХҮН

АНУ- 24,423,588

ЭНЭТЭГ- 12,078,333

БРАЗИЛ- 11,638,564

ОХУ- 4,258,279

ИХ БРИТАНИ- 3,961,738

ЦАХИМ ШУУДАНД



ЦАХИМ УУЛЗАЛТУУД  
ҮРГЭЛЖИЛСЭЭР

**Зэвсэгт хүчний  
016 дугаар нэгтгэл**

Нэгтгэл аймаг, дүүргүүдийн Цэргийн штабтай хамтран хугацаат цэргийн алба хаагчдыг интернэт орчин ашиглан гэр бүлтэй нь уулзуулах уулзалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Энэ удаад Дархан-Уул аймгийн

ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран тус нэгтгэлд Дархан-Уул аймгаас татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдаа аав ээж, элгэн садантай нь уулзууллаа. Хугацаат цэргийн алба хаагчид гэр бүл, хайртай хүмүүсээсээ урмын сайхан үг сонссондоо баяртай байгаагаа илэрхийлсэн юм.

**Ахмад Б.БАТГЭРЭЛ**

**АЛБА ХААГЧДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ  
ХАМГААЛАН АЖИЛЛАЖ БАЙНА**



**Зэвсэгт хүчний  
340 дугаар анги**

Ангийн Ахлагчийн зөвлөлөөс “Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний ахлагчийн эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх” албан даалгаврын хүрээнд ангийн Эрүүл мэндийн төв, Баян-Өлгий аймгийн 13 дугаар багт байрлах “Мейрим” өрхийн эмнэлгийн эмч, сувилагч нартай хамтран нийт бие бүрэлдэхүүний цусан дахь сахарын хэмжээг тодорхойлж, хеликобактерын

шинжилгээнд хамруулав.

Мөн Увс, Завхан аймгийн ЗДТГ, Цэргийн штабын бие бүрэлдэхүүнтэй хамтран 2020 оны II дугаар ээлжээр татагдсан 34 хугацаат цэргийн алба хаагчийг гэр бүлтэй нь уулзуулах цахим уулзалтыг зохион байгууллаа. Ахлах дэслэгч Г.Анхбаяр, ахлах дэслэгч З.Мэндсайхан, ахлах дэслэгч Ц.Захчин, дэслэгч Б.Долгорсүрэн нар цахим уулзалтын бэлтгэлийг ханган ажиллаж ангийн удирдлага, эцэг эхийн төлөөлөөс талархал хүртсэн юм. Мөн тус уулзалтаар богино хэмжээний урлагийн тоглолтыг зохион байгуулав.

**Г.БАЯРЦЭЦЭГ ӨРГӨӨ ЦАГААН  
ГЭРТЭЙ БОЛЛОО**

“TV9” телевизийн “Мөрөөдөл биелдэг юм” нэвтрүүлгийн уран бүтээлчид болон “Шинэ үе” продакшны захирал Н.Ариунболд, түүний охин А.Амин-Эрдэнэ, А.Номин-Эрдэнэ нар хамтран Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн талхан цехийн ажилтан Г.Баярцэцэг сэтгэлийн дэм үзүүлж, өргөө цагаан гэр бэлэглэлээ.

Г.Баярцэцэг нь Зэвсэгт хүчний 310 дугаар ангид 6 дахь жилдээ талхичнаар ажиллаж байгаа бөгөөд түүний найз Б.Оюунтулгал “Мөрөөдөл биелдэг юм” нэвтрүүлгийн редакцад захидлаар уламжлан хүсэлтээ илгээсэн нь ийнхүү биеллээ олжээ. Тус захидлыг Г.Баярцэцэгийн найз Б.Оюунтулгал энэ үеэр уншиж танилцуулсан юм. Арга хэмжээний үеэр ангийн захирагч, хурандаа Н.Баясгалан хэлэхдээ “Хамт ажилладаг найздаа чин сэтгэлийн тус, дэм үзүүлэх гэсэн энэ их зүтгэл, идэвх санаачилга үр дүнд хүрч, нэг ажилтан маань нийгмийн асуудлаа шийдвэрлүүлж байгаад ангийн удирдлага, бие бүрэлдэхүүнийхээ өмнөөс баяр хүргэе. Г.Баярцэцэгийнхээ ажилд нь өндөр амжилт, гэр бүлд нь сайн сайхныг хүсэн ерөөе. Мөн “Мөрөөдөл биелдэг

юм” нэвтрүүлгийн хамт олон болон өргөө цагаан гэр бэлэглэсэн МУГЖ Н.Ариунболдын охидод талархаж байгаагаа илэрхийлэе” гэв.

Эгч дүү А.Амин-Эрдэнэ, А.Номин-Эрдэнэ нар өөрсдийн эхлүүлсэн бяцхан бизнесээс олсон орлогоо сайн үйлсэд зориулахаар болж, “TV9” телевизийн “Мөрөөдөл биелдэг юм” нэвтрүүлгийн редакцад ханджээ. Ингээд тус редакцад ирсэн захидлуудтай танилцсаны эцэст Г.Баярцэцэгийн гэр бүлийг сонгосон байна.

Гэрийг хүлээлгэн өгсний дараа А.Номин-Эрдэнэ “Тус нэвтрүүлгийн редакцад маш олон захидал ирсэн байсан. Бид захидлаа сонгосныхоо дараа Г.Баярцэцэг эгчтэй уулзаж, ажилтай нь танилцахад халуун дулаан энергитэй хүн болох нь мэдрэгдсэн. Хийсэн сонголт маань нүдээ олсон тул бид ч их баярласан. Манай аав ээж сайн үйлсийн аян чимээгүй өнгөрөх тусмаа илүү үнэ цэнтэй гэж хэлдэг. Гэхдээ эгч бид хоёрын хувьд “Мөрөөдөл биелдэг юм” нэвтрүүлгээр дамжуулж үеийн залуустаа сайн үйлсийн төлөө чадах чинээгээрээ, чин сэтгэлээсээ өглөгийн гараа сунгаасай хэмээн уриалахыг хүссэн юм” гэв.

**ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭ СУРТАЛЧИЛЖ БАЙНА**

**Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын  
Цэргийн штаб**

Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб олон ажлыг зохион байгуулж байна.

Үүнд, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний ололттой, сайн талыг харуулсан телевизийн бичлэг, танилцуулах мэдээ, мэдээллийг аймгийн “Соёмбо”, “GMN” телевиз, “UVLIVE.MN” шууд нэвтрүүлэг, uvir-khangai.mn зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа. Мөн “Соёмбо”, “UVLIVE.MN” орон нутгийн телевизээр Цэргийн штабын дарга, хурандаа М.Дэлгэрсайхан үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хугацаат цэргийн алба хааж буй цэрэг дайчдын ар гэрийнхэн, аймаг, орон нутгийн иргэдэд хандаж мэдээлэл өгсөн юм. Тухайлбал, Зэвсэгт хүчний 032, 120, 167, 256, 339 дүгээр анги болон Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн удирдлагатай холбогдож, Арвайхээр, Хархорин, Хужирт, Богд, Уянга сумаас хугацаат цэргийн алба хааж буй 66 цэргийн ар гэрийн зарим төлөөллийг утсаар болон дүрсээр холбож яриулав. Түүнчлэн хугацаат цэргийн алба хаагчдын зарим ар гэрийн төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг сонссон юм.

Аймгийн Засаг дарга болон



сумдын Засаг дарга нарт үүссэн нөхцөл байдлыг тайлбарлахын сацуу тэдэнтэй хамтран Арвайхээр сумын 13, Хархорин сумын 4, Хужирт сумын 2, Бүрд сумын 1, Богд сумын 4, Уянга сумын 4, нийт 28 цэрэг дайчдын ар гэрт

гурил, цагаан будаа, гурилан боорцог зэрэг хүнсний бүтээгдэхүүнээс гадна амны хаалт, гар ариутгагч зэрэг ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнээр тусламж үзүүллээ.

**Дэд хурандаа Ч.АДЪЯА**


**ЦЭРГИЙН АЛБА ХААЖ БУЙ ХҮҮХДҮҮДЭЭ  
ЦАХИМААР “ЭРГЭВ”**

**Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын  
Цэргийн штаб**


Зэвсэгт хүчний 013, 014, 119, 311, 326, 336 дугаар анги, Хилийн 0101, 0243 дугаар ангитай хамтран хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдыг ар гэрийнхэнтэй нь цахимаар уулзууллаа. “Ковид-19” цар тахлын халдварын нөхцөл байдлаас хамааран үр хүүхдүүдээ эргэж чадахгүй байгаа эцэг эхүүдийг цахимаар уулзуулсан нь цагаан олсон арга хэмжээ болов. Энэ үеэр ар гэрийнхний зүгээс туйлын баяртай байна хэмээн баярласан сэтгэлээ илэрхийлж байлаа.

Мөн “Албаа нэр төртэй хааж байгаа хүүхдүүдээрээ бид бахархаж байна. Олон аавын хүүхдүүдтэй мөр зэрэгцэн эвтэй байж, дарга нарынхаа үгэнд сайн орж, сурч мэдэхийн төлөө шамдан, албаа нэр төртэй хаагаарай” гэж захиж байлаа.

**Дэд хурандаа Ч.ДАМДИНСРЭН**



**МИНИЙ ХҮҮ ӨНГӨЛӨГ, САЙХАН ЦЭРЭГ БОЛЖЭЭ**



**Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын  
Цэргийн штаб**

Улс орон даяар цар тахлын халдварын нөхцөл байдал амаргүй байгаатай холбогдуулан тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 032, 339 дүгээр анги, Хилийн 0214, 0130 дугаар ангитай хамтран эдгээр ангид хугацаат цэргийн алба хааж байгаа алба хаагчдыг ар гэрийнхэнтэй нь цахимаар уулзууллаа.

Энэ үеэр дайчдын ар гэрийнхэн “Албаа нэр төртэй хааж байгаа хүүгээрээ бид бахархаж байна. Бид сайн байгаа. Миний хүү өнгөлөг, сайхан цэрэг болжээ” хэмээн баяр хүргэж, олонтой эвтэй байж, албаа нэр төртэй хаахыг захиж байсан юм.

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИУДАА ДЭМЖИН  
АЖИЛЛАЖ БАЙНА**



**Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын  
Цэргийн штаб**

Аймгийн 2021 оны жилийн төлөвлөгөөнд туссаны дагуу Батлан

хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэдэд сурталчлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийг хөгжмийн

аппаратур, техник хэрэгслээр, Төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, хүндэт харуул жагсахад зориулж Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийг хивс, хивсэнцрээр, Зэвсэгт хүчний 116 дугаар тусгай салбарыг богино долгионы радио станцаар тус тус хангахаар төлөвлөн ажиллаж байгаа юм.

Тэгвэл эхний ээлжид 9 сая төгрөгийн үнэ бүхий хөгжмийн аппаратур, техник хэрэгслийг Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид хүлээлгэж өглөө.

**Хошууч Т.НУРБОЛАТ**